

## Зөрчлийн тухай хуульд заасан иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой заалт

Зөрчил	Хамаарах этгээд	Хүн (₮)	Хуулийн этгээд (₮)
3.4.2. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	Нийтээр	10,000-20,000,000	100,000-200,000,000
14.8.1. Иргэний нисэхийн багц дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл тусгай зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн	Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч	2,000,000	20,000,000
14.8.2. Хуулиар эрх олгогдсон этгээд нислэгийн аюулгүй байдлын, эсхүл аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй	Дарга, Байцаагч	- эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасаж; - 100,000	
14.8.3. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зөрчсөн	Нийтээр	300,000	3,000,000
14.8.4. Нислэгийн үед нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдээлээгүй	Хөлгийн дарга	- эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасаж; - 5,000,000	-
14.8.5. Иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой хамгаалагдсан бүсэд хууль бусаар нэвтэрсэн	Нийтээр	50,000	-
14.9.1. Агаарын зайн аюулгүй байдлын хяналтын үед нисэхэд ашиглах журам зөрчсөн	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	300,000	3,000,000
14.9.2. Агаарын зайн хяналтын үед илэрсэн зөрчлийг таслан зогсоох ажиллагааг хэтрүүлсэн	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ	50,000	500,000
14.9.3. Агаарын зайн зөрчил үйлдсэн	Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч	олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж	
		50,000	500,000

### 3.4 дүгээр зүйл. Торгох шийтгэл

1. Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.
2. Торгох шийтгэлийн хэмжээ нь хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй (10,000-20 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөг, хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй (100,000-200 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөг байна.
3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэг торгуулийн нэгж /цаашид “нэгж” гэх/ нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

### 3.6 дугаар зүйл. Эрх хасах шийтгэл

1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ.
2. Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно.
3. Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж оногдуулна.
4. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.

### 14.8 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль зөрчих

1. Иргэний нисэхийн багц дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл тусгай зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй (2 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй (20 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хуулиар эрх олгогдсон этгээд нислэгийн аюулгүй байдлын, эсхүл аюулгүй ажиллагааны үзлэг, шалгалтыг зохих журмын дагуу хийгээгүй бол үзлэг, шалгалт хийх эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг нэг зуун нэгжтэй (100,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зөрчсөн бол нисэхийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг гурван зуун нэгжтэй (300,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй (3 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Нислэгийн үед нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдээлээгүй бол мэргэжлийн эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж агаарын хөлгийн даргыг таван мянган нэгжтэй (5 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой хамгаалагдсан бүсэд хууль бусаар нэвтэрсэн бол хүнийг тавин нэгжтэй (50,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

### 14.9 дүгээр зүйл. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль зөрчих

1. Агаарын зайн аюулгүй байдлын хяналтын үед нисэхэд ашиглах журам зөрчсөн бол агаарын хөлгийн даргыг гурван зуун нэгжтэй (300,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй (3 сая ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Агаарын зайн хяналтын үед илэрсэн зөрчлийг таслан зогсоох ажиллагааг хэтрүүлсэн бол хүнийг тавин нэгжтэй (50,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй (500,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Агаарын зайн зөрчил үйлдсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж агаарын хөлгийн багийн даргыг тавин нэгжтэй (50,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй (500,000 ₮) тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.